МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.01.26 № А-1/170

танай ______________ -ны № ______________ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах тухай

Тус газраас зарласан ЗТХЯ/202412016 дугаартай XV.1.1.87 “Хар үзүүр, Ховд голын төмөр бетон гүүр, 217 у/м, хатуу хучилттай авто зам, 0.4 км /Баян-Өлгий, Алтанцэгц сум/” УТ2402804338 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын тендерийн баримт бичигт захиалагч Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн 2024 оны 03/281 дүгээр албан бичгийн дагуу дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

- ТШЗ 17.6.5. “2. Төсөвт техник, технологийн хяналтын зардал (зөвлөх үйлчилгээ), захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ (92,268,480.0 төгрөг), бусад татвар хураамжийг өөрийн төсөвт нэмж тооцож ирүүлнэ.” гэснийг “2. Барилга угсралтын ажлын төсөвт техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал 305,586,726.0 (гурван зуун таван сая таван зуун наян зургаан мянга долоон зуун хорин зургаа) төгрөг, зураг төсвийн үнэ 92,268,480.0 (ерэн хоёр сая хоёр зуун жаран найман мянга дөрвөн зуун ная) төгрөгийг өөрийн төсөвт нэмж тооцож ирүүлнэ. Өөр дүнгээр ирүүлсэн тохиолдолд технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлыг 305,586,726.0 төгрөгөөр, зураг төсвийн үнийг 92,268,480.0 төгрөгөөр тус тус тооцон тендерийн үнийг харьцуулж үнэлнэ.” гэж;
- ТШЗ 24.1. “Огноо: 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр. Цаг: 10 цаг 00 минут” гэснийг “Огноо: 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр. Цаг: 10 цаг 00 минут” гэж;
- ТШЗ 26.1. “2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр. Цаг: 10 цаг 10 минут” гэснийг “Огноо: 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр. Цаг: 10 цаг 10 минут” гэж тус тус өөрчлөв.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д дээрх өөрчлөлтийг тусгасан тендерийн баримт бичгийг шинэчлэн байршуулсан болно.

Дээрх тендер шалгаруулалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө зарласан тул 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж байгаа болохыг анхаарна уу.

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГА Ц.БАТЗУЛ

9020020105 СБТ-11251 6529909

1324020482

ТХААГ-2024-А4

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrtd.gov.mn,
Цахим хуудас: www.mrtd.gov.mn

2024.01.18 № 03/281

танай ____________-ны №____________-т

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 409 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад тусгагдсан 27 төсөл, арга хэмжээний эхний ээлжийн 14 төсөл, арга хэмжээний Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний ажлын зардлыг хавсралтаар хүргүүлж байна.

Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг аймаг тус бүрээр багц болгон зарлахыг хүсье.

Хавсралт 1... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

080000486

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 18 -ны өдрийн 03/281... тоот албан бичгийн хавсралт

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад тусгагдсан 27 төсөл, арга хэмжээний эхний ээлжийн 14 төсөл, арга хэмжээний Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний ажлын жагсаалт

| д/д | | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Эхлэх | Дуусах | Төсөвт өртөг | 2024 оны санхүүжих дүн | Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардал | Авто зам, гүүр-1 | Авто зам, гүүр-2 | Авто зам, гүүр-3 | Авто зам, гүүр-4 | ЦГС | холбоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Хэнтий аймаг** | | | | | | | | | | | |
| 1 | XV.1.1.92 | Хэрлэн голын төмөрбетон гүүр, 265 у/м, хатуу хучилттай авто зам, 14.2 км /Хэнтий, Хэрлэн сум/ | 2024 | 2026 | 54,472.50 | 16,341.70 | 1,945,081,218.00 | 1,069,796,647 | ########## | 1,215,001 | | | |
| | | **Дархан-Уул аймаг** | | | | | - | | | | | | |
| 2 | XV.1.1.99 | Шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Дархан сум/ | 2024 | 2025 | 9,723.00 | 4,861.50 | 356,653,330.00 | 356,653,330 | | | | | |
| | | **Төв аймаг** | | | | | - | | | | | | |
| 3 | XV.1.1.45 | Батсүмбэр сумаас Ахмад настны үндэсний төв хүртэлх хатуу хучилттай авто зам, гүүр, 10.7 км /Төв, Батсүмбэр сум/ | 2024 | 2026 | 13,338.90 | 4,001.70 | 484,201,560.00 | 440,413,133 | 43,788,427 | | | | |
| | | **Архангай аймаг** | | | | | - | | | | | | |
| 4 | XV.1.1.93 | Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хорго, Тэрхийн цагаан нуур хүртэлх хатуу хучилттай авто зам, 13 км /Архангай, Тариат сум/ | 2024 | 2026 | 26,000.00 | 7,100.00 | 961,929,364.00 | 955,673,926 | | | | 6,255,438 | |
| | | **Өвөрхангай аймаг** | | | | | - | | | | | | |
| 5 | XV.1.1.80 | Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 43.3 км /Өвөрхангай, Хужирт сум/ | 2024 | 2026 | 70,206.30 | 8,103.20 | 1,033,575,288.00 | 1,019,421,185 | 9,803,782 | | | | 4,350,321 |
| | | **Баянхонгор аймаг** | | | | | - | | | | | | |
| 6 | XV.1.1.47 | Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/ | 2024 | 2026 | 66,766.50 | 6,161.70 | 2,416,426,782.00 | 2,265,495,479 | ########## | 2,993,066 | | | |
| 7 | XV.2.1.7 | Түйн голын төмөр бетон гүүр, 64.75 у/м /Баянхонгор, Богд сум/ | 2024 | 2025 | 3,250.00 | 1,625.00 | 46,427,739.00 | | | | 46,427,739 | | |
| | | **Баян-Өлгий аймаг** | | | | | - | | | | | | |
| 8 | XV.1.1.87 | Хар үзүүр, Ховд голын төмөр бетон гүүр, 217 у/м, хатуу хучилттай авто зам, 0.4 км /Баян-Өлгий, Алтанцөгц сум/ | 2024 | 2026 | 9,165.70 | 1,249.70 | 305,586,726.00 | 305,586,726 | | | | | |
| 9 | XV.1.1.102 | Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дөрөвдүгээр хэсэг, 23.13 км /Баян-Өлгий/ | 2024 | 2026 | 46,888.9 | 11,688.6 | 1,694,401,316.00 | 1,694,401,316 | | | | | |
| | | **Завхан аймаг** | | | | | - | | | | | | |
| 10 | XV.1.1.78 | Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн улсын чанартай төв хатуу хучилттай авто замаас Идэр сум хүртэлххатуу хучилттай авто зам, 12.06 км /Завхан, Идэр сум/ | 2024 | 2026 | 16,846.90 | 3,000.00 | 633,280,830.00 | 633,280,830 | | | | | |
| | | **Говь-Алтай аймаг** | | | | | - | | | | | | |
| 11 | XV.2.1.4 | Завхан голын төмөр бетон гүүр /Говь-Алтай, Жаргалант сум, Бүрэн баг/ | 2024 | 2026 | 8,928.0 | 1,000.0 | 264,912,038.00 | 264,912,038 | | | | | |
| | | **Увс аймаг** | | | | | - | | | | | | |
| 12 | XV.1.1.43 | Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Увс, Улаангом сум/ | 2024 | 2026 | 3,602.00 | 1,080.60 | 52,541,110.00 | | 52,541,110 | | | | |
| 13 | XV.1.1.79 | Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/ | 2024 | 2026 | 46,659.10 | 6,840.30 | 1,726,307,843.00 | 1,718,761,448 | | | | 7,546,395 | |
| 14 | XV.2.1.5 | Туруун голын төмөр бетон гүүр, 109.15 у/м, Бухын голын 9.6 у/м гүүр, 1.1 км авто зам /Увс, Баруунтуруун сум/ | 2024 | 2026 | 6,431.5 | 1,929.5 | 212,204,453.00 | 146,770,718 | 20,779,032 | 44,654,703 | | | |